

## МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХУВЬСГАЛ БА ХЯТАД, ТАЙВАНИЙ ТҮҮХ БИЧЛЭГ ДЭХ ЗАРИМ АСУУДАЛ

*(Монголын үндэсний эрх чөлөөний хувьсгалын 100 жилийн ойн нээлтэд зориулсан эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан илтгэл)*

Д.Шүрхүү\*

Энэхүү илтгэлийн гол зорилго бол Хятад, Тайваний түүх бичлэгт 1911 оны Монголын үндэсний эрх чөлөөний хувьсгалын асуудал хэрхэн тусгагдсан тухай товч өгүүлэхийн зэрэгцээ Монголын түүхчид, эрдэмтэд түүнийг хэрхэн үзэх, цаашид юу хийвэл зохистой вэ гэдэг талаар өөрийн санал дүгнэлтийг сонордуулахыг хичээлээ.

Үндсэн сэдэвтээ орохын өмнө бяцхан дурсамж өгүүлмээр байна. 2009 оны 5-р сард БНХАУ-ын Орчин үеийн олон улсын харилцааны академиас эрхлэн Бээжин хотноо зохион байгуулсан “Монгол, Хятадын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ой: хамтын ажиллагаа, хөгжил” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын үеэр Монгол-Хятадын харилцааны тулгамдсан асуудалд “Гадаад Монголын тусгаар тогтнол”, “Монгол-Хятадын хэсэг мөн”, “Чингис Хятадын хаан мөн эсэх” гэх мэт түүхийн асуудлууд орох эсэх талаар нэлээд маргасан юм. Хятадын талын нөхдүүд түүхийн асуудлыг хойш нь тавъя, орчин үеийн асуудалдаа анхаарлаа хандуулья, маргаантай асуудлыг мэргэжлийн судлаач түүхчдэд үлдээе гэж байсан. Эндээс ямар сэтгэгдэл төрсөн бэ гэхлээр хэзээ, хаана, хэнтэй ямар асуудлыг хэлэлцэх, маргах мэтгэлцэх нь зүйтэй бас үр дүнтэй хэмээн бодогдсон юм. Зарим хүмүүс маргаантай зөрчилтэй асуудлыг ил тод ярих хэрэг байна уу ч гэж асууж магадгүй. Өнөөдөр бол энэ талаар ярих, хэлэлцэх цаг үе, мөн хурлын сэдэвт ч нийцэж байна гэдгийг хэлэх гэсэн юм.

1911 оны Монголын үндэсний эрх чөлөөний хувьсгалын сэдэв бол Хятад, Тайваний түүхчид, судлаачдын ХХ зууны эхэн үеийн зохиол бүтээлд ямагт хөндөгддөг эмзэг бөгөөд чухал сэдэв юм. Харин тэд хэрэглэдэг нэр томъёо машид өөр бөгөөд “Гадаад Монголын тусгаар тогтнол” үг хэллэгийг ихээхэн түгээмэл хэрэглэдэг. Эрт үед ч, одоо ч бид бүхний анхаарвал зохих зүйл бол Хятад, Тайваньд хэвлэгдсэн судалгааны ном, өгүүллийн нэр, гарчиг юм. Хамгийн сүүлийн нэгэн жишээ бол Хонконгийн долоо хоног тутмын “Фэнхуан” /凤凰 Phoenix weekly/ сэтгүүл 2010 оны №32 дугаараа Монголын асуудалд зориулсан байна. Тус сэтгүүлд Монгол Улсын ардчилал, зах зээлд шилжсэн үйл явц, хүндрэл бэрхшээл, үр дагаврын тухай, мөн Монгол-

\* Д.Шүрхүү - ОУСХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор

Хятадын харилцааны өнөөгийн байдал, Хятадыг “шахах” далд давалгаа болон хятад эсрэг үзэлтэй үндсэрхэх үзэлтнүүдийн үйл ажиллагааг хөндөн бичсэн байлаа. Гэхдээ “Монголын тусгаар тогтнолын эхлэл төгсгөл” жижиг өгүүлийг оруулжээ. Өгүүлийн эхэнд сэтгүүлч “Гадаад Монголын тусгаар тогтнол гэдэг бол олон олон хятад хүний мартаход хэцүү сэтгэлийн эмзэглэл бөгөөд эцсийн эцэст Монгол хэрхэн салан тусгаарласан, түүхэнд Хятад улс Монголыг эргүүлэн авах бодитой боломж байсан эсэх, Хятадын эх газрын интернетээр Монгол Хятадтай эргэж нийлэх боломжтой хэмээн ихэд шуугин бичсээр байгаа нь хэр бодитой вэ? Өнөөгийн монголчууд хятад хүний энэ эмзэглэлд хэрхэн ханддаг вэ гэсэн” бяцхан оршил тавьсан байна. Хятад, Тайваньд хэвлэгдсэн, цаашид ч хэвлэгдэх 1911 оны Монголын үндэсний эрх чөлөөний хувьсгал, тусгаар тогтнолоо сэргээсэн талаарх ном, товхимол, судалгаа, сурталчилгааны өгүүлүүд бүгд дээрх асуултуудад хариулахыг хичээх нь тодорхой юм.

Манай нэрт түүхч Л.Жамсран Монголын үндэсний эрх чөлөөний хувьсгалын түүхийг нэлээд олон жилийн турш нягт нямбай судалсан нэгэн бөгөөд нанхиад сурвалж, судалгааны зохиолуудыг ном бүтээлдээ түлхүү ашигласан байдлаараа нэлээд ялгардаг. Л.Жамсран доктор хамгийн сүүлд туурвисан томоохон нэгэн сэдэвт зохиолоо “Монголын төрийн тусгаар тогтнолын сэргэлт” хэмээн нэрлэсэн нь ч ихээхэн бодож тунгаасны үр дүн, нөгөө талаар хятад хүмүүсийн дээрх эмзэглэл, Монгол яах бол гэсэн асуултын дорвитой хариулт болох юм.

Хятад, Тайваньд өгүүлэн буй сэдэвтэй холбогдол бүхий ном, товхимлын нэрэнд “Гадаад Монгол”, “тусгаар тогтнол”, “эхлэл төгсгөл”, “хаант оросын түрэмгийлэл” гэсэн үг хэллэг нэлээд орсон байдаг. Америкийн нэрт монголч эрдэмтэн О.Латтимор “Нүүдэлчид ба хувьсгалчид” номондоо “Монголчууд 1911 онд юуг хүсэж байсан бэ гэвэл бүрэн тусгаар тогтнол болно. Манжийн эзэнт төрийн эсрэг боссоноор тэд Монгол болон Хятадыг холбож буй холбоос зохиомол гэдгийг нотлохыг оролдсон юм. Манжууд ХҮИ зуунд эхлээд Хятадыг, дараа нь Монголыг тус тусад нь эзлэн дагуулсан. Тиймээс ч манжууд унахын хамт холбоос тасарсан юм”<sup>1</sup> гэжээ.

Хятадын түүхчид Монгол, Хятад хоёрыг нэг дээвэр дор оруулсан манжийн холбоосыг зохиомол гэдгийг хүлээн зөвшөөрч чадахгүй, өнө мөнхийн байх ёстой мэтээр үздэг. Тэдний бичсэнээр Монгол тусгаар тогтносон үндсэн шалтгаан бол Хятадын тархай бутархай байдал, төр засгийн хүчин чадал мөхөсдсөн явдал бөгөөд монголчууд бие даасан төр улсаа байгуулан мандаж явсан, харь гүрний эрхшээлд хэсэг хугацаанд байсны эцэст төрийн тусгаар тогтнолоо сэргээн бэхжүүлж,

бүрэн эрхтэй улс болохын төлөө цөхрөлтгүй тэмцсээр ирсэн шийдвэрлэх хүчин зүйлийг төдийлөн чухалчилж үзэлгүй орхигдуулдаг.

Мөн хятадын түүх бичлэгт Монголын тусгаар тогтнолд гадны оролцоо, ялангуяа Хаант Оросын хатгаас, ил далд цэрэг, улс төр, эдийн засгийн дэмжлэгийг онцлон тэмдэглэдэг. Жишээ нь, Жао Зя-иний 1994 бичиж хэвлүүлсэн “Хятадын ойрхи үеийн дипломатийн түүх” номонд “Хүрээнд сууж байсан Оросын консул Монголын ван гүн, лам нарыг Хятадад хувьсгал гарсан нэн тааламжтай энэ цаг хугацааг Халхыг тусгаар тогтноулахад ашиглахгүй байж болохгүй хэмээн ятган, улмаар 1912 оны 12-р сарын 1-нд Гадаад Монголын хэсэг лам ноёд гэнэт “тусгаар тогтнол” гэгчийг зарлан, Сандоо амбаны яамыг бүслэн, манж цэргүүдийн зэвсгийг хураасан хэмээн”<sup>2</sup> бичжээ. Тайваний түүхч Люй Цювэний 1976 онд бичиж хэвлүүлсэн “Хятад, Орос, Гадаад Монголын харилцааны эхлэл төгсгөл” номондоо “Дундад иргэн улс дөнгөж байгуулагдаад байсан тэрхэн үед бүгд найрамдах гэдэг нь юу болохыг монгол хүн хараахан ойлгоогүйн дээр түүний шашин шүтлэгийг устгана гэж эндүү ташаа ойлгож байсан тал бий. Мөн Монголын нийгмийн байгуулал нь ангийн бүтцийн хувьд ван гүнгүүд ард түмнийг боол мэт үзэх, богд гэгээнтэн нь дур зоргоороо авирлах байдал ноёрхож ирсэн зэрэг нь өнө эртний түүхтэй адил тэгш бүгд найрамдахыг зэрэг хэргэмтэн лам хуврагуудын үл хүсэх зүйл буюу”<sup>3</sup> хэмээн бичиж байв.

Монголын тусгаар тогтнолыг зөвхөн Хаант Орос дэмжлэг түлхээс, эсвэл империалист Япон, Их Британи зэрэг их гүрнүүдийн далд тохиролцоо, нөлөөний хүрээгээ хуваасны үр дүн хэмээн үзэх хандлага Хятадын болон өрнөдийн түүх бичлэгт ч мөн давамгайлдаг. О.Латтимор 1911 оны Монголын үндэсний эрх чөлөөний хувьсгалын эхэн үед их гүрнүүд Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхөөс зайлсхийж байсан шалтгааныг сонирхолтой хэлбэрээр тайлбарласан байдаг. Тэрбээр “Британи Төвдийг, Орос ч Монголыг авч үзэхдээ аль аль нь Хятадад харьяалагдах боловч үнэндээ Хятадын нэг хэсэг биш гэж ойлгож байлаа. Тэд нэг талаар Хятад, Монгол болон Төвдийг холбож байсан нь зөвхөн Манжийн хааны асуудал гэсэн Монгол, Төвдийн нотолгоог бүрэн дүүрэн дэмжээгүйтэй адил нөгөө талаар Монгол, Төвд нь Хятадын бүрэлдэхүүн болно гэсэн Хятадын нотлогоог бүрэн дүүрэн дэмжээгүй юм. Ингэснээр тэд Төвд болон Монголын бүрэн тусгаар тогтнолыг Хятадаар хүлээн зөвшөөрүүлэх хариуцлагаас мултгарсан төдийгүй Төвд болон Монголыг өөрсдөөсөө тус тус тусламж гуйхаас өөр аргагүй байдалд хүргэжээ”<sup>4</sup> гэсэн сонирхолтой гаргалгааг хийсэн байна.

Хятад, Тайваний түүх бичлэгийн уламжлалт судалгаа болох хил хязгаарын холбогдолтой судалгааны бүтээлүүдэд Монголын тусгаар тогтнол, үндэсний эрх чөлөөний хувьсгалын асуудал, ялангуяа Хаант

Орос Хятадын нутаг дэвсгэрийг хууль бусаар таслан авсан, Гадаад Монголыг өдөөн турхирч салган холдуулсан гэх мэт байдлаар хөндөгдсөн байдаг. Дашрамд өгүүлэхэд Хятадын хил хязгаар хэмээх ойлголтонд юуг хамруулах асуудал өнөөг хүртэл маргаантай асуудал хэвээр байна. БНХАУ нь олон мянган жилийн түүхтэй, 55 цөөнх үндэстэнтэй, өргөн удам нутаг дэвсгэртэй том орон тул хил хязгаарын түүхийг хэрхэн авч үзэхэд багагүй асуудал бэрхшээл тулгардаг. Тухайлбал, хил хязгаарт зөвхөн хань үндэстний түүхэнд хамаарах газар нутгийг хамруулах аваас дээрх цөөнх үндэстний түүхийг бүхэлд нь огоороход хүрнэ. Харин үндэстний цөөнхийн түүхийг бүхэлд нь хамруулан авч үзэх тохиолдолд зарим цөөнх үндэстний нэг хэсэг нь хилийн чанадад буй тул зөвхөн тухайн үндэстний Хятадын нутаг дэвсгэр дэх хэсгийн түүхийг бичихэд хүрнэ.<sup>5</sup> Хятадын түүхчид энэ талаар янз бүрийн байр суурь гаргалгааг хийдэг бөгөөд судлаач Тань Цисян (譚其驤) нэгэн өгүүлэлдээ, “бид эртний хүний сэтгэл зүрхэнд буй “Хятад”-аар Хятад улсын зааг хязгаар хийж болохгүйн адил өнөөгийн Хятадын хил хязгаараар манай түүхийн хил заагийг тогтоож болохгүй гэжээ”. Тэрбээр цааш нь бичихдээ, Цин гүрний нэгтгэн захирч дууссаны дараахь, их гүрнүүд Хятадад түрэмгийлсний өмнөх үеийн нутаг дэвсгэр, тодруулбаас 18-р зууны 50-аад оноос 19-р зууны 40-өөд оны хар тамхины дайн хүртэл үеийн Хятадын нутаг дэвсгэрийг манай түүхэн нутаг дэвсгэр гэж үзвэл зохистой<sup>6</sup> гэж дүгнэсэн байна. Энд онцлон анхаарууштай зүйл бол дээрх үзэл хандлагыг хятадын ихэнх түүхчид ч, өргөн олон түмэн ч санал нэгтэй хүлээн авдаг явдал юм. 1993 онд Хятадад хэвлэгдэн, манай талын шаардлагын улмаас ил тарааж борлуулах явдлыг зогсоосон “Гадаад Монголын тусгаар тогтнолын далд нууц” (外蒙古独立内幕) номын утга санаа бол Гадаад Монгол бол дээр дурдсан Хятадын түүхэн нутаг дэвсгэрийн салшгүй бүрэлдэхүүн байсан бөгөөд Хаант Оросын хатгалгаар бий болсон Гадаад Монголын тусгаар тогтнол гэгчийн харгайгаар асар удам баян тансаг нутгаа хятадууд алдсан гэдгийг нотлоход оршиж байв. Гэхдээ зөвхөн нэг удаагийн номыг хааж хориглосноор хятад хүний дотоод сэтгэлд ул суурьтай хадагдсан Гадаад Монгол бол Хятадын салшгүй бүрэлдэхүүн хэсэг байсан, боломж гарвал эргүүлэн авах ёстой гэсэн үзэл ойлголтыг өөрчилнө, бууруулна гэж үзвэл хэт гоомой зүйл болох болов уу. Мэдээллийн технологи үсрэнгүй хөгжиж буй өнөө үед /<http://www.waimenggu.com.cn>, <http://news.phoenixtv.com> гэх мэт/ Хятадын янз бүрийн вэб сайтууд дээр Гадаад Монголыг алдсан түүх, учир шалтгааныг халаглан шүүмжлэн бичихийн зэрэгцээ Хятад эдгээр нутаг усаа эргүүлэн авахыг уриалсан, шаардсан санал сэтгэгдлүүд

гарсаар байна. Хэдийгээр эдгээр өгүүлэл материалууд нь албан ёсны бус шинжтэй, хувь хүний байр суурь мэт харагдавч судлаачид, улс төрчид хэрхэвч огоорч үл болох, тодорхой түвшинд мэдээлэл судалгаатай байж зохих хэмжээнд няцаалт өгч байх ноцтой асуудал юм.

Сүүлийн жилүүдэд БНХАУ, Тайваньд ч улс төрийн нөхцөл байдал өөрчлөгдөн, үзэл суртлын хатуу хяналт суларч тодорхой түвшинд үндэсний үзлийг хүлээн зөвшөөрч эхэлсэнтэй уялдан Хятадын сурвалж бичиг, архивын шинэ шинэ баримтууд судалгааны эргэлтэнд орж буй нь Монголын түүхийн судалгаа, түүний дотор Монголын үндэсний эрх чөлөөний хувьсгалтай холбогдох шинэ мэдээлэл, баримт олж авах, түүхийн үнэнийг судлан тогтооход чухал хэрэглэгдэхүүн болгон ашиглах боломж ч нэмэгдэж байна. Цаашид хоёр орны эрдэмтэн судлаачид Зүүн Хойд Азийн 3 орон Япон, Хятад, Солонгосын жишээгээр түүхийн маргаантай асуудлаар хамтарсан судалгаа хийх, хамтын бүтээл гаргах зэрэг чиглэлээр хамтран ажиллаж үзэл хандлага, байр суурийн зөрүүгээ бууруулах, олон түмэнд зөв ойлголт өгөх талаар хүчин чармайлтаа нэгтгэвэл хоёр орны сайн хөршийн харилцан итгэсэн түншлэлийн харилцаанд ч багагүй хувь нэмэр болох буй заа.

Цаашид эрдэмтэн судлаач бид нарын хийвэл зохих ажлууд:

- Юуны өмнө Хятад, Тайвань, Хонконгод Монголын түүх, түүний дотор Монголын Үндэсний эрх чөлөөний хувьсгал, тусгаар тогтнол, сэргэн мандлын талаар гарсан судалгааны зохиол, сурвалж бичиг, албан ёсны танин мэдэхүй-сурталчилгааны материал /сэтгүүл, сонин, вэб сайт/-уудыг системтэй тогтмол судалж, Монгол Улсын эрх ашгийн үүднээс ул суурьтай үнэлэлт дүгнэлт хийх,
- Дээрх судалгааг хийх, ер нь Монголын түүх судлалд нэн шаардлагатай буй хятад, манж хэлийг сайн эзэмшсэн мэргэшсэн түүхч нарыг байнга бэлтгэх,
- Монголын Үндэсний эрх чөлөөний хувьсгал, тусгаар тогтнолын талаарх Хятад, Тайвань, Хонконгийн судалгаанд гарч буй түүхийн гуйвуулга, Монголын тусгаар тогтнол, бүрэн эрх, түүх соёлын талаарх буруу ташаа ойлголт, үнэлэлт дүгнэлтийг яаран сандран сэтгэлийн хөөрлөөр хүлээж авч, нэр хүнд, ашиг хонжоо хөөцөлдөн ухвар мөчид бодлын үүднээс нийтэд сүржин зарлан тунхаглаж, түмэн олны сэтгэл санааг үймүүлэн тарамдуулахаас урьд төр засаг, асуудлыг эрхэлсэн хариуцлагатан лугаа мэдүүлэн учир зүйд нийцүүлэн хэрхэхийг шийдвээс наанадаж судалгаандаа дэмтэй цаана нь төрийн бодлогыг зөв тийш залж чиглүүлэхэд тустай болой.

- Хятад, Тайваний түүхийн судалгааны байгууллага, эрдэмтэдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх /хамтарсан судалгаа хийх, хурал симпозиум зохион байгуулах, баримтын эмхэтгэл, судалгааны ном зохиол бичих, судлаач солилцох, залуу эрдэмтдийг дадлагажуулах, ном сэтгүүл солилцох/ Хамтын ажиллагаа хөгжүүлнэ гэдэг эсрэг талынхаа үзэл бодол, байр суурийг хүлээн зөвшөөрнө, түүхийн үнэнийг хэлэх амаа хамхина гэсэн үг огт биш бөгөөд харин ч тэдний үзэл баримтлалын мөн чанар, учир шалтгааныг ухан ойлгохуйн сацуу өөрсдийн байр суурь, ойлголтын үндэс гаргалгаагаа тэдэнд мэдрүүлэн таниулбаас хоёр тал түүхийн ээдрээ төвөгтэй эмзэг асуудлуудаар мугуйдлан зөрүүдлэж муудалцан толжилцох нь багасах учиртай.

Сайдлаа гээд нийлж болдоггүй, муудлаа гээд нүүж болдоггүй мөнхийн хөрштэйгээ эв найртай, амар тайван өнө мөнхөд зэрэгцэн аж төрөхийн тулд монгол, хятад хоёр ард түмнийг бие биенээ үзэн ядах, атгаг хар муу санаа, мунхаг бурангуйн хорсол зэвүүдлээс ангид байлгахад түүхч эрдэмтдийн үүрэг оролцоо багагүй билээ.

### ЭШЛЭЛ, ЗҮҮЛГ

1. О.Латтимор. “Нүүдэлчид ба хувьсгалчид”, Улаанбаатар 1994, 44 дэх тал
2. Жао Зя-ин. “Хятадын ойрхи үеийн дипломатийн түүх”, Бээжин 1994, 515 дахь тал
3. Люй Цювэн. “Хятад, Орос, Гадаад Монголын харилцааны эхлэл төгсгөл” Тайбэй-1976, 10-15-р тал
4. О.Латтимор. “Нүүдэлчид ба хувьсгалчид”, Улаанбаатар 1994, 45 дахь тал
5. 中国通史, 白寿彝 主编, 上海出版社 1989, 页 70, 79
6. Тань Цисян, “Хятадын хилийн түүх-газар зүйн судалгаа” - 谭其骧 “中国边疆史地研究” (1991 年 1 期)